

**“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

24/01

Огноо: 2024 оны 4 сарын 30

Цаг: 15:00

Хурал хуралдуулах газар /хаяг, байршил/: Цахим хэлбэрээр (Ард Апп)

Хурал зарлагч: Төлөөлөн Удирдах Зөвлөл

Хурлын дарга: Г.Уянга

Хуралд оролцсон: Хурал зохион байгуулах комисс, Хурлын дарга, Хувьцаа эзэмшигчид, Тооллогын комиссын гишүүд

“Хөвсгөл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг энэхүү хурлын дэгийн дагуу 15:00 цагт нээв.

ХУРЛЫГ НЭЭСЭН НЬ:

Г.Уянга: Өдрийн мэнд, Өнөөдрийн хурлыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 24/02 дугаартай тогтоолын дагуу Хурлын даргаар Г.Уянга би даргална. Иймд та бүхэнд өнөөдрийн хурлын дэгийг танилцуулъя. (хурлын дэгийг танилцуулав.) За ингээд хурлын дэгийн дагуу 2024 оны 04 сарын 30-ны өдрийн хурлын ирцийн талаар мэдээлэхийг тооллогын комиссын бүрэлдэхүүнээс хүсэж байна.

Тооллогын комисс: Өнөөдрийн “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн тухай танилцуулъя. Компанийн нийт гаргасан саналын эрхтэй нийт 51,956 ширхэг хувьцаанаас 48,680 ширхэг буюу 93.69 хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэв.

Г.Уянга: Энэхүү хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулав. ХЭХ-ийн материалыг хувьцаа эзэмшигчдэд БДК-аар дамжуулан илгээж, холбогдох журамд заасны дагуу танилцах нөхцөл боломжоор хангасан тул уншиж танилцсан байгаа байх. Иймд хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудал тус бүрээр холбогдох танилцуулгыг хийж танилцуулъя.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хэлэлцэх асуудал №1,3 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах

Г.Сэлэнгэ: Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосноор танилцуулж, уг тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг мөн танилцуулав.

Хэлэлцэх асуудал №2 Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах.

Г.Сэлэнгэ: Компанийн 2024 оны 02 сарын 08-ны өдрийн 24-01 дугаартай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын дагуу Компани нь 2023 оны санхүүгийн жилд үйл ажиллагаа явуулаагүй тул компанийн санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан 2024 онд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Хэлэлцэх асуудал №4 Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх.

Г.Сэлэнгэ: Өнөөдрийн байдлаар Компанийн зарласан хувьцааны тоо нийт 51,956 ширхэгийн байгаа ба Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 86,655,338 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 86,707,294 ширхэг байхаар байна.

Хэлэлцэх асуудал №5 Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах

Г.Сэлэнгэ: Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 126.17 төгрөгийн ханшаар тооцон 86,655,338 ширхэг энгийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон Компани нарын хооронд байгуулсан Авлагын гэрээний холбогдох заалтын дагуу 10,933,304,000 төгрөгийн өглөгийг энгийн хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэж, Компанийн өрийг энгийн хувьцаанд хөрвүүлэх төслийг танилцуулж, хэлэлцэв.

Хэлэлцэх асуудал №6 Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох

Г.Сэлэнгэ: Компанийн өрийг хувьцаагаар сольж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах гэж буйтай холбогдуулан нийт 10,933,304,000 төгрөгийн үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний гэрээ, хэлцэл байгуулахаар байна.

Хэлэлцэх асуудал №7 Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх

Г.Сэлэнгэ: Компаниас нэмж гаргах 86,655,338 ширхэг энгийн хувьцаанаас хувьцаа эзэмшигчдэд өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй гэж заасны дагуу олгохоор байгаа юм.

Хэлэлцэх асуудал №8 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг шинээр томилох

Г.Сэлэнгэ: Компанийн дүрмийн 6.2 дахь хэсэгт ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгоно гэж заасны дагуу Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүд болох Ч.Хандаа, О.Амарболд, Ц.Тайшир, Г.Сэлэнгэ, Ж.Алтангүний нар болон хараат бус

гишүүд болох Ц.Оюун, Ц.Эрдэнэчимэг, Ц.Батбаяр нарын 2 жилийн хугацаа нь энэхүү хурлаар дуусаж байгаа юм. Иймд Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдэд Ч.Ганхуяг, Б.Золбоо, Ц.Тайшир, Г.Уянга, Г.Сэлэнгэ, Ч.Даваасамбуу, хараат бус гишүүдэд Т.Батзул, Г.Зол-Эрдэнэ, Ж.Дамдинцэрэн нарын нэр дэвшүүлж байна.

Хэлэлцэх асуудал №9 Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнээр тооцон 86,655,338 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 86,707,294 ширхэг байхаар хэлэлцсэн Компанийн холбогдох хэсгүүдэд дараах нэмэлт, өөрчлөлт орсон байгаа.

ганийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталснаар өөрчлөх хэсгүүд

Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлт

4.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд компани нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 51,956 ширхэг энгийн зарласан хувьцаатай байна.

4.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд компани нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 86,707,294 ширхэг энгийн зарласан хувьцаатай байна.

4.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 100 (зуу) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 51,956 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.

4.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 100 (зуу) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 86,707,294 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.

АСУУЛТ, ХАРИУЛТ

Байхгүй.

САНАЛ ХУРААЛТ

Тооллогын комисс:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 48,680 ширхэг буюу 93.69 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 48,680 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

1.1. Санал хураалтын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал;

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 3

Хувьцааны тоо 48,680 ширхэг.

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100 %

1.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

1.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 48,680 ширхэг буюу 93.69 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 48,680 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

2.1. Санал хураалтын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал:

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 3

Хувьцааны тоо 48,680 ширхэг.

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100 %

2.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

2.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

3. Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 48,680 ширхэг буюу 93.69 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 48,680 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

3.1. Санал хураалтын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал:

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 3

Хувьцааны тоо 48,680 ширхэг.

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%

3.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

3.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

4. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 48,680 ширхэг буюу 93.69 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд 48,460 ширхэгийн хувьцаа эзэмшигч нь саналын эрхгүй тул энэхүү хэлэлцэх асуудалд 220 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгөх эрхтэй ба тус 220 ширхэгийн хувьцаа эзэмшигч нь урьдчилсан саналын хуудсаар санал өгснөөс:

4.1. Санал хураалтын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал:

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 2

Хувьцааны тоо 220 ширхэг.

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%

4.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

4.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

5. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдах авах эрхийг эдлүүлэх эсэх тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 48,680 ширхэг буюу 93.69 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос 48,460 ширхэгийн хувьцаа эзэмшигч нь саналын эрхгүй тул энэхүү хэлэлцэх асуудалд

220 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгөх эрхтэй ба тус 220 ширхэгийн хувьцаа эзэмшигч нь урьдчилсан саналын хуудсаар санал өгснөөс:

5.1. Санал хураалтын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал:

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 2

Хувьцааны тоо 220 ширхэг.

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%

5.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

5.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох тухай асуудлаар хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 48,680 ширхэг буюу 93.69 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 48,680 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

6.1. Санал хураалтын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал:

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 3

Хувьцааны тоо 48,680 ширхэг.

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100%

6.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

6.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

7. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 48,680 ширхэг буюу 93.69 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд хурлаар 48,680 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

7.1. Санал хураалтын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал:

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 3

Хувьцааны тоо 48,680 ширхэг.

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 100 %

7.2. Хуралдааны үеэр ирүүлсэн цаасан санал:

Ирцэнд орсон боловч цаасан санал байхгүй байна.

7.3. Хүчингүй санал.

Ирцэнд орсон боловч хүчингүй болсон санал байхгүй байна.

Г.Уянга: Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулсан тул 2024 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийг танилцуулъя. Дараах шийдвэрүүдийг уншиж танилцуулав. 1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, 2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх, 3. Компанийн өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах, 4. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, 5. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн

хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх, 6. ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилох, 7. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт осон төслийг батлах

ХУРЛЫН ХААЛТ:

Г.Уянга: Үүгээр өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье. Хурлыг зохион байгуулсан ажлын хэсэг болон тооллогын комиссын бүрэлдэхүүнд баярлалаа. Хурал хаалаа.

Хянасан,

Хурлын дарга Г.Уянга

Тэмдэглэл хотолсон,

Б.Оюунсүвд:



Бүх